

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 24 дугаар тогтоолын хавсралт

ТУСГАЙЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭР, МАГАДЛАЛЫН БҮТЭЦ, АРГАЧЛАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.1, 75¹, 75², 75⁴-т зааснаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлал нь **удиртгал, үндэслэх, тогтоох** хэсгээс бүрдэнэ. Шийдвэр, магадлалд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлал”, түүний хавсралтад заасан “...хэвлэмэл хуудас хэрэглэх, уг үсгийн дүрэм, баримт бичгийн стандарт”-ыг нэгэн адил баримтлах бөгөөд шүүхийн шийдвэр, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангасан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол мөн адил бүтэц, хэлбэртэй байна.

Нэг.Удиртгал хэсэг

1.1.Шийдвэрийн удиртгал хэсэгт шүүхийн ямар шийдвэрийг хэзээ, хаана, аль шүүх гаргаж байгаа, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.

1.2.Магадлалын удиртгал хэсэгт давж заалдах шатны шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, хэзээ, хаана, анхан шатны шүүхийн ямар шийдвэрийг хянан хэлэлцсэн болон шүүх хуралдааны оролцогчийг нэрлэн заана.

Хоёр.Шийдвэрийн үндэслэх хэсэг

2.1.Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл /сөрөг нэхэмжлэл, хариу тайлбар/, бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тайлбар, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг товч тусгана.

2.2.Нэхэмжлэл болон сөрөг нэхэмжлэлийг хангах, зарим хэсгийг хангах, бүхэлд нь хэрэгсэхгүй болгох талаар буюу нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэж буй үр дүнг дурдана.

2.3.Нэхэмжлэлийн үндэслэл байдал, зохигчийн гаргасан нотлох баримтыг үнэлж маргааны үйл баримтыг тогтоох, маргааны зүйлийг тодорхойлох, талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааг тодорхойлох, нэхэмжлэлийн /сөрөг нэхэмжлэлийн/ шаардах эрхийн хэм хэмжээг сонгох, тогтоогдсон үйл баримтад үндэслэн холбогдох хуулийг хэрэглэх, шийдвэр биелүүлэх нэмэлт хугацаа тогтоосон үндэслэлийг тусгах дарааллаар нэхэмжлэлийн /сөрөг нэхэмжлэлийн/ шаардлагыг хэрхэн шийдвэрлэсэн эрх зүйн дүгнэлт, үр дүнг тусгана. Иргэдийн төлөөлөгч оролцсон бол дүгнэлтийг хэрхэн үзэж буй үндэслэл, шүүхийн зардал, улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн шийдвэрлэснийг товч тусгана.

Гурав.Магадлалын үндэслэх хэсэг

3.1.Хэргийн оролцогчийн гаргасан давж заалдах гомдлыг бүхэлд нь эсвэл гомдлын хүрээнд хянаад гомдлыг хангах, заримыг хангах, эсвэл хангахгүй орхиж буй эсэхийг тусгана.

3.2. Нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл /сөрөг нэхэмжлэл, хариу тайлбар/, бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тайлбар, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн товч агуулгыг тусгана.

3.3. Анхан шатны шүүх маргааны үйл баримт, маргааны зүйлийг зөв тогтоосон эсэх, хэрэглэвэл зохих хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн эсэх, давж заалдах гомдлыг бүхэлд нь эсвэл заримыг хангасан, эсвэл хангаагүй талаарх магадлалын үндэслэлийг товч тусгана.

3.4. Давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд хяналтын журмаар гомдол гаргахгүй үр дагаврыг сануулсан байна.

Дөрөв. Шийдвэр, магадлалын тогтоох хэсэг

4.1. Шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсэг захиран тушаах хэлбэртэй байх бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5, 167 дугаар зүйлийн 167.1, 167.2-т заасан шаардлагад нийцсэн байвал зохино.

4.2. Шүүхийн шийдвэр ойлгомжтой, тодорхой, биелэгдэх боломжтой бүх нэхцэлийг хангасан байна.

4.3. Тогтоох хэсэгт шүүгч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

4.4. Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хөндөөгүй байна.

4.5. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹¹.2-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэхийг тусгасан байна.

Монгол Улсын дээд шүүхийн нийт шуугчийн
хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны
өдрийн 11 дугаар тогтоолын 1 дугээр хавсралт



ШИЙДВЭР

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

... анхан шатны ...шүүхийн шүүгч ... даргалж, тус шүүхийн танхимд хийсэн иргэний хэргийн шүүх хуралдаанаар,

Нэхэмжлэгч: ... нэхэмжлэлтэй,

Хариуцагч: ... -д холбогдох,

Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд:

... тухай үндсэн нэхэмжлэлтэй, .

...тухай сөрөг нэхэмжлэлийн шаардлагатай иргэний хэргийг **тусгайлсан журмаар хянан хэлэлцэв.**

Шүүх хуралдаанд ... нар оролцов.

ҮНДЭСЛЭХ нь:

1. Нэхэмжлэлийг /үндсэн болон сөрөг/ бүхэлд нь, эсхүл заримыг хангах, эсхүл нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож байгаа эсэхийг дурдана.

2. Маргааны үйл баримтыг тогтоож, маргааны зүйлийг тодорхойлсон байна..

3. Нэхэмжлэлийн /үндсэн болон сөрөг/ шаардлага, үндэслэл, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл, бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдийн тайлбарын агуулгыг товч тусгана.

4. Талуудын хооронд үүссэн эрх зүйн харилцааг тодорхойлсон байна.

5. Шаардах эрх, шаардах эрхийн урьдчилсан нөхцөл, түүний үгүйсгэлийн талаар товч тодорхой дүгнэсэн байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75⁹ дүгээр зүйлийн 75⁹.1, 115 дугаар зүйлийн 115.2..., 75⁹.2 дугаар зүйлийг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1. Дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

-нэхэмжлэлийн шаардлагыг хангах

-нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох

-нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох

2:хуулийн дагуу улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг шийдвэрлэсэн байна.

3.шийдвэрийг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 7 хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэйг дурдана..

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Загвар

МАГАДЛАЛ

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

А-ЫН НЭХЭМЖЛЭЛТЭЙ
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТУХАЙ

... давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч ... даргалж, шүүгч ..., нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд хийсэн давж заалдах шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар,

Анхан шатны шүүхийн нэр, шийдвэрийн огноо, дугаар

Нэхэмжлэгч: ...,

Хариуцагч: ... -д холбогдох,

Нэхэмжлэлийн шаардлага..., сөрөг нэхэмжлэл....ийг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг-ны гаргасан давж заалдах гомдлыг үндэслэн, шүүгч ...-ны илтгэснээр хянан хэлэлцэв.

Шүүх хуралдаанд: нар оролцов.

ХЯНАВАЛ:

1.Хэргийг бүхэлд нь хянан хэлэлцээд давж заалдах гомдлыг хангасан эсэхийг дурдана.

2.Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага, үндэслэл, хариуцагчийн татгалзал, түүний үндэслэл, бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдийн тайлбарын товч агуулгыг тусгана.

3.Анхан шатны шүүх маргааны үйл баримт, маргааны зүйлийг зөв тогтоосон эсэх, хэрэглэвэл зохих хуулийг хэрэглэсэн, хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн эсэх талаар давж заалдах шатны шүүх хэрхэн үзсэн тухай эрх зүйн дүгнэлт;

4.Давж заалдах гомдолд хариулт өгөх. /Хянавал хэсгийн 3-т хамтатган дүгнэх эсхүл тусад нь дүгнэх/

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.-д заасныг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1.1.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих,

1.2.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаах,

1.3.Анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, эвлэрлийг батлах,

- 1.4.Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, зохиgчдын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох,
- 1.5.Анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах
- 2.Улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн зардлыг хэргийн оролцогчдод хуваарилах
- 3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 75¹¹ дүгээр зүйлийн 75¹¹.2-т зааснаар давж заалдах шатны шүүх хэргийг эцэслэн шийдвэрлэх учир хяналтын журмаар гомдол гаргах эрхгүйг дурдана.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

ШҮҮГЧИД